



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Г“Жонон даатгал” ХХК-д даалгавар өгөх тухай Г


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3, Даатгалын тухай хуулийн 67.1.1, 67.1.3, 68.1.4, 73.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Жонон даатгал” ХХК-д өөрийн дүрмийн сангаа Хорооноос тогтоосон доод хэмжээнд 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргэхийг даалгасугай.

2. Тогтоосон хугацаанд Хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болохыг “Жонон даатгал” ХХК /Ш.Жаргалсайхан/-д анхааруулсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН